

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМД

2024 оны 03 дугаар сарын 15 өдөр

Улаанбаатар хот

Шинээр илэрсэн нөхцөл байдлын үлмаас шүүхийн
шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлт гаргах нь

Хүсэлт гаргагч: Уурагч овгийн Энхтөгсийн Оюунболд /РД:СР93031417/

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 17-р хороо, их монгол улс гудамж 128-байр 133 тоот

Утас: 99112463

Хянуулах шийдвэрүүд: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 06 дугаар сарын 14 өдрийн 423 дугаартай шийдвэр, Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2020 оны 07 дугаар сарын 21 өдрийн 0438 дугаартай магадлал, Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн танхимын 2020 оны 11 дүгээр сарын 02 өдрийн 398 дугаартай тогтоол.

Миний бие Монгол түмний уламжлалт соёлын нэг, Үндэсний бөхийн спортоор бага наснаасаа хичээллэж, өөрийн бүхий л хүчин чармайлт бэлтгэл сургуулилт хичээл зүтгэлээр Тулгар төрийн 2228, Их Монгол Улс байгуулагдсаны 813, Ардын хувьсгалын 98 жилийн ойн баяр наадамд барилдсан 512 бөхөөс 9 даван түрүүлж Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлигаар Улсын аварга цол хүртсэн байсан.

“Монголын үндэсний допингийн эсрэг байгууллага” тухайн наадамд 16-д үлдсэн бөхчүүдээс сэргээшийн шинжилгээ авч бөхчүүдийн шээсний дээжийг БНСУ-ын шинжлэх ухаан, технологийн институтийн Сэргээшийн хяналтын төв лабораторид шинжлүүлсэн байдаг. Уг шинжилгээгээр 4377891 дугаартай сэргээшийн шинжилгээний дүгнэлтээр миний шээсний А дээжид сэргээшийн шинжилгээний эм зүйн ангилалд хамаарах хориотой 4 төрлийн бодис /S1.1A бүлгийн Станозолол, S4 бүлгийн Мелдониум, S5 бүлгийн Гидрохлортиазид, Хлортиазид/ илэрсэн гэж дүгнэлт гарсан.

Уг дүгнэлтийг үндэслэн Үндэсний их баяр наадмын Үндэсний бөхийн салбар хороо 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар Э.Оюунболдын шинжилгээнд сэргээшийн төрлийн бодис илэрсэн талаарх асуудлыг хэлэлцэж, улмаар Үндэсний бөхийн салбар хорооны 2019 оны 09 дүгээр сарын 02 өдрийн 08 дугаар албан бичгээр санал хүргүүлж, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар Сэргээшийн шинжилгээний дүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 08 дугаар тогтоол гаргаж, Тулгар төрийн 2228, Их Монгол Улс байгуулагдсаны 813, Ардын хувьсгалын 98 жилийн ойн Үндэсний их баяр наадмын хүчит бөхийн барилдаанд түрүүлж Монгол Улсын аварга цолны болзол хангасан Э.Оюунболдын уг барилдаанд барилдаж давсан даваа тус бүрийг хүчингүйд тооцож, Э.Оюунболдод барилдах эрхийг 2 жилийн хугацаанд хасаж, надад унасан бөхчүүдэд цол олгуулах саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж шийдвэрлүүлэхээр болсон.

Дээрх шийдвэрийг миний бие эс зөвшөөрч Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны 2019 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн Сэргээшийн шинжилгээний дүнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 08 дугаар тогтоолыг Э.Оюунболдод холбогдох хэсгүүдийг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийн шаардлага гаргасан. Захиргааны хэргийн анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож давж заалдах шатны шүүх болон хяналтын шатны шүүхүүд зарим заалтуудад өөрчлөлт оруулж агуулгын хувьд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

Миний бие шүүхэд гаргасан нэхэмжлэлийнхээ үндэслэлдээ “би сэргээшийн төрлийн хориотой бодис огт хэрэглээгүй байхад шинжилгээгээр илэрсэн гэж байгаад маш их гайхаж байна, Намайг наадамд түрүүлж болохгүй, бууж өгөх хэрэгтэй, эс тэгвээс сэргээшийн шинжилгээгээр унагаана гэж сүрдүүлж байсан тохиолдол ч байгаа, надаас авсан **шинжилгээний хариу өөрөө маш их эргэлзээтэй**, шинжилгээний А сорьц авахаас эхлээд шинжилгээний хариу гарах хүртэл ямар нэгэн байдлаар хууль бус үйл ажиллагаа явагдсан байж болзошгүй, шинжилгээ өөрөө үнэн зөв баталгаатай болох нь нотлогдоогүй гэж маргасан. Анхан шатны шүүх дээрх тайлбар үндэслэлийг хэрэгт авагдсан **нотлох баримтаар тогтоогдохгүй байна гэж дүгнэсэн**.

Гурван шатны шүүхүүд агуулгын хувьд Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллагын авсан 4377891 дугаартай сэргээшийн шинжилгээний дүгнэлт нь хүчин төгөлдөр гэж дүгнэн миний нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах үндэслэл:

Монгол Улсын Засгийн газар 2005 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр “Спортод сэргээшийн эсрэг Копенхагены тунхаглалд нэгдэн орох тухай” 79 тоот тогтоолоор Копенхагены тунхаглалыг хүлээн зөвшөөрч, 2007 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн “Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг олон улсын конвенцид Монгол улс нэгдэн орсныг соёрхон батлах тухай” хуулиар “Спорт дахь допингийн эсрэг ЮНЕСКО конвенцид нэгдснээр, Дэлхийн допингийн эсрэг дүрмийг хүлээн зөвшөөрсөн.

Дэлхийн допингийн эсрэг дүрмийн 5.1 шинжилгээ авах эрх бүхий байгууллага гэж Монгол улсын хувьд Монголын Допингийн эсрэг байгууллага юм. Эрх бүхий байгууллага нь допингийн эсрэг шинжилгээ авахдаа олон улсын дүрэм болон стандартаар хяналтын ажилчдыг сонгох томилох, ажиглагч нарыг сонгох томилох, дээжийн сав бэлдэх, дээж авах байрыг сонгох баталгаажуулах шээх үйл явцыг хянах зэрэг бүхий л үйл ажиллагааг хянаж шалгаж дээрх дүрэм журамд нийцүүлэн дээж авах үйл ажиллагааг зохин байгуулах үүрэгтэй.

Мөн “Үндэсний их баяр наадмын бөх, харваачид сэргээшийн шинжилгээ хийх журмын”-ын 7.1-д бөх сэргээш хэрэглэсэн тухай дүгнэлт нь Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан шийтгэл оногдуулах үндэслэл болох ба 7.3-д Үндэсний их баяр наадмын зохион байгуулах хороо нь сэргээш хэрэглэсэн эсэх тухай салбар хороо болон допингийн эсрэг төвийн дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргахаар журмалсан.

Допингийн эсрэг шинжилгээ авах үйл ажиллагааг зохин байгуулсан, сэргээш хэргэлэсэн эсэх дүгнэлтийг гаргасан этгээдүүд Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагыг 2017 оны 02 сарын 23 өдрөөс хойш төлөөлөх эрхгүй, хууль бус байсан нь тогтоогдож улмаар улсын бүртгэлээс хасагдсан байна.

Допингийн эсрэг байгууллагыг төлөөлөх эрхгүй этгээдүүдийн аливаа шийдвэр нь тухайн байгууллагыг төлөөлөх эрх зүйн үндэслэлгүй гэж үзвэл тэдний гаргасан баяр наадмын оролцогчдоос шинжилгээ авах шинжээч томилсон, ажиглагч томилсон, шинжилгээний сав сонгосон, шинжилгээ авах үйл ажиллагаа, шинжилгээ төлөвлөх үйл явц, гэх мэт 2019 оны баяр наадмын үеэр шинжилгээтэй холбоотой бүхий л бичиг баримт нь хууль бус гэж ойлгогдож байна.

Хэрэв миний нэхэмжлэлийг хянан шийдвэрлэгдэж байсан 2019 оны цаг хугацаанд Монголын үндэсний допингийн эсрэг байгууллагын төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, дээж цуглуулсан этгээдүүд нь төлөөлөх эрхгүй хууль бус байсан нь мэдэгдсэн бол тухайн байгууллагыг төлөөлөх эрх зүйн чадамжгүй этгээдүүдийн гаргасан бүхий л шийдвэр, албан бичгүүд нь хүчин төгөлдөр бус болох нь тогтоогдож нэхэмжлэлийн үндэслэл нотлогдож нэхэмжлэлийн шаардлага өөрөөр шийдэгдэх боломжтой байсан.

Өөрөөр хэлбэл маргаан бүхий актын үндэслэл болсон Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллагын авсан 4377891 дугаартай шинжилгээ нь хууль бус болох нь нотлогдох байсан.

Шинээр илэрсэн нотлох баримтын талаар

Гурван шатны шүүх Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллагын авсан 4377891 дугаартай шинжилгээг эцсийн үнэн зөв гэж үнэлж дүгнэн хэргийн эцэслэн шийдвэрлэсэн. Гэтэл шинжилгээ авсан байгууллага нь хууль бус удирдлагатай хууль бусаар бусдын гарын үсгийг хуурамчаар зурж гэмт хэргийн шинжтэй үйлдлээр допингийн эсрэг байгууллагын эрх мэдлийг авсан байна.

Миний бие нэр бүхий этгээдүүд хууль бусаар Монголын допингийн эсрэг байгууллагын эрх мэдлийг авсан гэдэг мэдээллийг олон нийтийн мэдээллээс 2024 оны 03 дугаар сарын 14 өдөр олж мэдээд¹¹ Улсын бүртгэлийн ерөнхий газрын нээлттэй цахим мэдээллийн сан болох www.opendata.burtgel.gov.mn сайтын мэдээллийн санг шалгаж үзэхэд допингийн эсрэг байгууллагын 2017 оноос хойших бүх бүртгэлийг нь хүчингүй болгож хассан талаар олж мэдлээ.

Шүүхийн шийдвэр гарах үед Монголын допингийн эсрэг байгууллага хууль бус бүрэлдэхүүнээр шинжилгээ авсан нь мэдэгдээгүй байсан, энэ нотлох баримт нь шүүхийн шийдвэрийн үндэслэлд нөлөөлж болохуйц баримт 2024 оны 03 дугаар сарын 14 өдөр ил

1. <https://www.itoim.mn/a/2024/03/14/sport/suy>
2. www.opendata.burtgel.gov.mn

болсон учраас миний бие Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.1 заасан үндэслэлээр хүсэлт гаргаж байна.

Иймд Монголын допингийн эсрэг байгууллагын эрх мэдлийг хууль бусаар авч төлөөлөх эрхгүй этгээдүүд шинжилгээ авах ажиллагааг зохин байгуулсан нь одоо мэдэгдэж байгаа тул Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 06 дугаар сарын 14 өдрийн 423 дугаартай шийдвэр, Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2020 оны 07 дугаар сарын 21 өдрийн 0438 дугаартай магадлал, Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн танхимын 2020 оны 11 дүгээр сарын 02 өдрийн 398 дугаартай тогтоолыг хүчингүй болгож хэргийг дахин хянуулах хүсэлтийг хангаж өгнө үү.

Хавсаргасан баримт

1. Хүсэлт /4/ хуудас
2. <https://opendata.burtgel.gov.mn/> хуулбар 1 хуудас
3. <https://www.itoim.mn/a/2024/03/14/sport/suu> ярилцлага /7/ хуудас
4. Иргэний үнэмлэхийн хуулбар 1 /хуудас/

Хүсэлт гаргасан

Уурагч овгийн Энхтөгсийн Оюунболд /РД:СР93031417/

...*Э. Оюунболд*.....

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 17-р хороо, их монгол улс гудамж 128-байр 133
тоот Утас: 99112463